

НОГООН ХУУДАС ХЭРХЭН АШИГЛАХ ТАЛААР

Номын энэ хэсэгт орчин үеийн эмийн талаарх мэдээлэл өгнө. Хэрэв та уламжлалт эм хэрэглэхийг хүсэж байгаа бол гэр болон ажлынхаа ойр байрлах уламжлалтын эмнэлэг эсвэл эмчээс мэдээлэл авч болно. Уламжлалт эмийг зарим газарт хэрэглэдэг ч зарим газарт огт хэрэглэдэггүй.

Аюулгүй эм авах талаар

Зөвхөн шаардлагатай үед л эмийг ашиглаарай.

Олон хүмүүс өвчтэй үедээ эм тариа хэрэглэхгүй бол бие нь сайжрахгүй гэдэгт итгэдэг. Энэ бол буруу ойлголт юм. Зарим өвчний шинж тэмдэг тухайлбал ханиад хүрэхэд удаан хугацаагаар амрахад хамгийн сайн эдгэрдэг. Мөн сайн чанарын хоол, цэвэр ус хангалттай хэмжээгээр хэрэглэх нь хамгийн сайн шийдэл болж өгнө. Иймээс эрүүл мэндийн ажилтнууд таныг өвдөх бүрт өөр өөр эм бичиж өгөхөд их л анхаарал болгоомжтой хандах хэрэгтэй.

Эмийг курсээр хэрэглэх

Та эмийг удаан хугацаанд хэрэглэхээр эхэлсэн бол эмчийн зөвлөсний дагуу л хэрэглэх ёстой. Заримдаа, эмийг курсээр нь хэрэглэж байгаа ч өвчин дахих боломжтой юм. Энэ нь эмийг урт хугацаанд хэрэглэхэд өвчний үүсгэгчид (бактери, вирус г.м) нөлөөлж чадахгүй эмийн дасалд хүргэж болно.

Хэт их хэмжээгээр хэрэглэж болохгүй

Эмчийн бичиж өгсөн тун, хэмжээнээс хэтрүүлж эмийг хэрэглэвэл магадгүй таныг бүр их өвдсөн үед тохирох эм олдохгүй болно.

Эмийн үзүүлэх нөлөөг мэдэх, харах

Зарим эм хортой гаж нөлөө эсвэл тухайн хүнд харшлын урвал үүсгэж болох тул маш аюултай юм (хуудас 329 г үзнэ үү).

Эмийн талаар ихийг сурч мэдэх

Эмийн талаар эрүүл мэндийн ажилтан эсвэл эм зүйчээс асуу. Хэрэв та эмийн талаар мэдээлэл авахаар бол энэхүү номын ногоон хуудас эсвэл “эмчгүй газарт” номноос олж уншиж болно.

Амаар уух (шахмал, капсул) эмнүүд нь тарьж хэрэглэхээс аюулгүй

Энэхүү номоор бид амаар уух эмийг сонгож хэрэглэхийг санал болгож байна. Хэрэв тэд амаар уух эмийг хэрэглэж чадахгүй бол тарьж хэрэглэх ёстой. Хэрэв танд тариа хэрэгтэй бол, эрүүл мэндийн ажилтан гэсэн хэсгээс үзнэ үү. Аюулгүй тарих талаарх мэдээллийг “эмчгүй ч эмэгтэйчүүд байгаа газарт” номын 542 нь 544 хуудаснаас олж уншиж болно.

Нэг эм хосолсон болон илүү үнэтэй эмнээс аюулгүй

Гэхдээ зарим эм ялангуяа ХДХВ/ДОХ-ын эмийг хослуулан хэрэглэх нь илүү хялбар байна.



- Боломжтой бол та эм уухдаа зогсож эсвэл суугаа байршилд уух хэрэгтэй. Мөн та эм уух бүрдээ нэг аяга ус заавал уух ёстой.
- Та эм уухдаа бөөлжсөн бол бөөлжсөө харж уусан эм тань гарсан эсэхийг ашиглах хэрэгтэй. Хэрэв эм бөөлжсөөр гарсан бол дахин эмээ ууна.
- Хэрэв та жирэмслэхээс сэргийлэх эм ууснаас хойш 3 цагийн дараа бөөлжсөн бол дахин жирэмслэхээс сэргийлэх эмээ уух хэрэгтэй.

ТАНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН УЛМААС ХЭРЭГЛЭДЭГ ЭМИЙГ БУСАД ЭМТЭЙ ХАВСРАН ХЭРЭГЛЭХ НЬ


Хэрэв та хөгжлийн бэрхшээлийн улмаас байнга эм ууж байгаа бол зарим эмтэй хавсран хэрэглэж болохгүй байж болох юм. Таны хөгжлийн бэрхшээлийн улмаас байнга уудаг эм бусад эмийн үйлчлэлийг өөрчлөх эсвэл бусад эм нь таны байнга уудаг эмийн үйлчлэлийг өөрчлөж болно. Тухайлбал, та эпилепсийн фенитоин уудаг бол эстроген болон прогестин агуулсан жирэмслэхээс сэргийлэх эм хэрэглэвэл багтрах шинж илэрнэ. Та байнга уудаг эм болон уух шаардлагатай болсон бусад эмийн хавсрах нөлөөллийн талаар мэдэхийн тулд туршлагатай эрүүл мэндийн ажилтан, эм зүйчээс эмийн талаар харилцан ярилцаж, хэрэв тохирохгүй бол ямар эмээр орлуулж болох талаарх мэдээллийг авч болно. Энэ номын жагсаалтад бүх эмийн харилцан үйлчлэлийн талаар ороогүй. Гэхдээ зарим эмийн үйлчилгээ болон бусад эмтэй хэрхэн харилцан үйлчлэх талаарх мэдээллийг олж уншиж болно.



Харшил

Зарим хүмүүс эмийн харшилтай байдаг. Хэрэв харшил төрүүлэх эмийг хэрэглэсэн бол тухайн хүний бие хариу урвал үзүүлнэ. Хариу урвал нь биеийг тавгүйтэх (арьсны тууралт, арьс болон нүд загатнах, нүүр, уруул хавагнах, хоолой сөөх г.м) эсвэл амь насанд маш ноцтой хүндрэлд (цонхийх, арьс барзайх, зүрх болон судасны цохилт түргэсэх эсвэл багасах, амьсгалахад бэрхшээлтэй болох, цусны даралт багасах, ухаан алдах г.м) хүргэж болно. Хэрэв хүн харшлын улмаас ухаангүй болбол маш яаралтай эмнэлгийн тусламж авах хэрэгтэй. Хэрэв та харшилтай бол гэр бүлдээ хэрэглэдэг эмнээс авч хэрэглэхгүй байх мөн харшилдаг эмээ хэрэглэхгүй байх ёстой (Гэр бүлийн антибиотекийн хэрэглээ, хуудас 330-331 үзнэ үү).

Эмийн нэр



Эм ихэвчлэн 2 нэртэй байдаг. Эмийн ерөнхий (эсвэл шинжлэх ухааны) нэр нь дэлхийн хаана ч адил нэртэй байна. Зарим эмийн үйлдвэр, компаниуд нь эм бүртээ өөрийн брэнд нэрийг өгдөг. 2 өөр компанийн үйлдвэрлэсэн нэг ижил эм нь өөр, өөр брэнд нэртэй байдаг. Энэхүү номонд бид эмийн ерөнхий нэршлийг ашигласан. Хэрэв та ерөнхий нэр нь л ижил бол ямар ч брэндийн эмийг орлуулан хэрэглэж болно. Зарим брэнд эмнүүд бусад эмнээсээ илүү бага үнэтэй байдаг.

Эмийн тун хэмжээ

Ихэнх шахмал, капсул болон тариагаар хэрэглэх эмнүүд нь грамм (гр), миллиграмм (мг), микрограмм (мкг) эсвэл нэгж (U) гэсэн хэмжих үзүүлэлтээр хэмжигддэг байна:

1000 мг = 1гр (1000 мг нь 1 гр-тай тэнцүү)

1 мг = 0.001 гр (1 нэг мянганы 1 хэсэг нь 1 мг-тай тэнцүү)

Зарим эмнүүд ялангуяа жирэмслэхээс сэргийлэх эмнүүд нь микрограмм-аар хэмжигддэг (мкг эсвэл ucg):

1ucg= 1 мкг = 1/1000 мг = 0.001 мг.

Энэ нь 1000 мкг нь 1 мг-тай тэнцүү гэсэн гэсэн үг юм.

Тарилгаар хэрэглэгддэг эмнүүд нь нэгж (U) буюу олон улсын нэгж (IU)-ээр хэмжигддэг байна.

Эмийн хэлбэр

Эм өөр өөр хэлбэртэй бөгөөд энэхүү номонд бид эмийг хэрхэн хэрэглэх ёстойг харуулсан зургийг ашиглана:



Ер нь, эмийг уухаар хэрэглэх нь тарьж хэрэглэснээс илүү эрсдэлгүй байдаг. Гэхдээ яаралтай үед үйлчилгээг нь түргэсгэх зорилгоор тарих нь илүү үр дүнтэй байна.

Энэ зураг нь үгээр бол АНХААРУУЛГА болно. Хэрэв эмэгтэй жирэмсэн эсвэл хөхүүл хүүхэдтэй бол онцгой анхаарах хэрэгтэй гэдгийг харуулна.



Эмийн төрөл

Эмийн хэд хэдэн төрлийн талаарх мэдээллийг энэхүү номонд оруулсан. Эмийн нэг төрөл болох антибиотик, үүнийг тайлбарлах хэрэгтэй.

Антибиотик

Антибиотик нь бактерийн халдварын үед хэрэглэгддэг. **Антибиотикийг вирусийн гаралтай ханиад, элэгний үрэвсэл (халдварт шар) эсвэл ХДХВ/ДОХ зэрэг өвчний үед хэрэглэхэд эмчлэгдэхгүй.** Өөр хоорондоо төстэй үйлчилгээ үзүүлдэг антибиотекийг нэг бүлгийн антибиотек гэж нэрлэдэг. Хэрэв та антибиотек хэрэглээд дээрдэхгүй бол нэг бүлгийн өөр антибиотекийг нь хэрэглэж болно. Хэрэв та нэг антибиотект харшилтай байлаа гэхэд тэр бүлгийн антибиотекуудаас хэрэглэж болохгүй.

Зарим нэг антибиотик болон тэдний бүлгийн антибиотекийн жагсаалт:

Пенициллин: амоксициллин, ампициллин, пенициллин бензатин, бензилпенициллин, диклоциллин г.м

Макролидүүд: Азитромицин, эритромицин г.м

Тетрациклины бүлгийн: Доксциклин, тетрациклин

Сульфас (сульфонамид): Сульфаметазоле (котримексазоле) г.м

Тэмдэглэл